



**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн
Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3, 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.12 заалт "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.5, 5.6, 5.7 дахь заалт "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.1, 2.4, 2.8, 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Ж.Ганбаатар;

Гишүүд

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга С.Бат-Эрдэнэ;
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ж.Гантулга;
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь;
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Г.Лхагвахатан;
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Ч.Баярцолмон;
Аймаг дахь Шүүхийн Тамгын газрын дарга Б.Баярсайхан;
Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Ч.Эрдэнэбаатар;
Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Сүнгээ;
Хэрлэн сумын ЗДТГ-ын дарга Г.Болд;

ТАЗ тогтоол 2019

19000137


Салбар зөвлөлийн
нарийн бичгийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-ийн
Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан
мэргэжилтэн Ж.Саруултөгс

2.Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Ж.Ганбаатарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишгийг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 105 дугаар тогтоол, “Аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, дарга нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 141 дүгээр тогтоолын 21 дэх хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн даргын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 107 дугаар тушаал, “Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн даргын 2014 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 105 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ